Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хэлтэс

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын орчин, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж, арга хэмжээний хэрэгжилтийг үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг | - | - | - | - | | Бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын орчин, сурах бичиг, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилтын хүрээнд дараах ажлуудыг амжилттай зохион байгууллаа. - Боловсролын сайдын А/59, А/101 дүгээр тушаалын дагуу “Mozaik Kiady Kft” компанитай 2024 онд байгуулж, 6–12 дугаар | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэх | | | | | ангийн цахим контент, дижитал сурах бичгийн системийг нэвтрүүлж эхэлсэн. БЕГ-ын даргын А/18 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, техник орчныг бүрдүүлэн 705 сургуулийн 22,680 багш, 377,804 сурагчийг medle.mn домайн хаягаар бүртгэж, 2 серверийг үндэсний түвшинд суурилуулсан. Үндэсний хэмжээнд 30 сургагч багшийг бэлтгэж, системийг түгээн дэлгэрүүлж байна. Унгар улсад сургалтад хамрагдсан 11 эксперт контент баяжуулах чиглэлээр 3D үзүүлэн, цахим хичээл, видео зэрэг 200 гаруй материал, 3 гарын авлагыг нутагшуулан боловсруулахад хамтран ажилласан. - Цахим платформд 6–12 дугаар ангийн 100 сурах бичгийг байршуулж, шаардлага хангахгүй номыг сайжруулах ажил үргэлжилж байна. Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчид | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулсан видео хичээл, заавар, гарын авлагыг бэлтгэж, сургуулиуд дэмжигч багшийн тогтолцоотой болсон. Үндэсний сургагч багш нар 1200 гаруй багшид, мөн үндсэн сургалтаар 10,000 гаруй багшид цахим системийг таниулсан бөгөөд 2025.05.30-ны байдлаар 22000 гаруй багш системд бүртгэгдсэн байна. - БЕГ, МХСН болон ЖАЙКА хамтран “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол, практикийн бага хурлыг 2025 онд амжилттай зохион байгуулж, 208 багшийн илтгэлийг хүлээн авч, 51 илтгэлийг II шатанд шалгаруулан шагналт байранд 6 илтгэл орж, шалгарсан илтгэлүүдийг цахим ном болгон олон нийтэд хүргэлээ. Ийнхүү үндэсний хэмжээнд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, арга зүйн дэмжлэгийг шат дараатай, үр дүнтэй хангаж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллалаа. Хавсралт: 6 файл | | |
| 1.1.1 | Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим системийг VI-XII ангид нэвтрүүлнэ. (Mozaik) | 7 тэрбум 169 сая төгрөг | Цахим платформд нэвтэрсэн багш, суралцагчын хувь | - | 6 хувь | 80 хувь | Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн системийг нэвтрүүлэх ажил (6–12 анги) нь Боловсролын сайдын 2024 оны А/59, А/101 дүгээр тушаалын хүрээнд хэрэгжиж байна. Гүйцэтгэгчээр “Mozaik Kiady Kft” ХХК шалгарч, Боловсролын ерөнхий газартай 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. БЕГ-ын даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>- Техник, орчны бэлэн байдлыг хангах хүрээнд серверийн техникийн үзүүлэлтийг боловсруулан БМТТ-д хүргүүлж, 705 сургуулийн 22,680 багш, 377,804 сурагчийг medle.mn домайн хаягаар нэвтрэх эрхээр хангаж, хэрэглэгчийн мэдээллийг баталгаажуулсан. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол улсад байрлах 2 серверийг БЕГ-т байршуулсан. - Үндэсний сургагч багшаар 30 багшийг танхимын сургалтаар бэлтгэж, орон нутагт платформыг түгээн дэлгэрүүлж байна. - Унгар улсад 11 эксперт сургалтад хамрагдаж, агуулга баяжуулах, орчуулах, монгол өв соёлыг тусгах, мультимедиа хичээл бэлтгэх чиглэлээр арга барил эзэмшсэн. 3D үзүүлэн 711, цахим хичээл 243, видео бичлэг 111, гарын авлага 3-ыг сайжруулах ажил хийгдэж байна. - Аймаг, нийслэлийн боловсролын газар болон 55 туршилтын сургуулийн удирдлагатай уулзалт зохион байгуулсан. - Үндэсний сургагч багш нар 1200 гаруй багшийг сургалтад хамруулж, 5,10,15 дахь жилдээ багшилж буй багш нарын үндсэн сургалтаар 10,000 гаруй багшид цахим системийг таниулсан. - 6–12 дугаар ангийн 100 сурах бичгийг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | платформд байршуулсан бөгөөд шаардлага хангахгүй байгаа зарим сурах бичгийг дахин сайжруулах ажил үргэлжилж байна. - Багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид зориулсан видео хичээл, заавар, гарын авлагыг боловсруулан цахим хуудас, youtube сувгаар дамжуулан хүргэж, платформын дэмжигч багшийг сургууль бүрд ажиллах тогтолцоог бүрдүүлсэн. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу хэрэгжилт шат дараатай, үр дүнтэй зохион байгуулагдаж байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.2 | “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах аргазүй-Сурагч төвтэй хичээл, үйл ажиллагаа" онол практикийн IX бага хурал зохион байгуулах | Батлагдсан төсвийн хүрээнд | Оролцсон оролцогчдын тоо, хувь | - | 100% | - | Боловсролын Ерөнхий Газар, Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэг хамтран, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгтэйгээр “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол, практикийн бага хурлыг 2013 оноос | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хойш тогтмол зохион байгуулж ирсэн. 2025 онд тус хурлыг ес дэх удаагаа “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй – Суралцагч төвтэй хичээл, үйл ажиллагаа” сэдвийн хүрээнд хоёр үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Илтгэлийн уралдааныг үнэлэх, хэлэлцүүлэх ажлыг Боловсролын Ерөнхий Газрын судлагдахуун хариуцсан 9 мэргэжилтэн, Боловсролын Судалгаа Үнэлгээний Хүрээлэнгийн 2 судлаач, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн 10 багш, Монгол Улсын Их Сургуулийн 4 багш, Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэгийн 12 сургагч багшийн бүрэлдэхүүнтэй, нийт 36 хүнээс бүрдсэн баг гүйцэтгэв. Тус хуралд нийслэл болон орон нутгаас нийт 208 багшийн илтгэл хүлээн авч, I шатны шалгаруулалтад хамруулсан бөгөөд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үүнээс II шатанд 51 багшийн илтгэл шалгарсан юм. Уралдааны дүнгээр 6 илтгэлийг шагналт байр эзлүүлж, шилдэг 2 номинацид тусгай шагнал олголоо. Энэ нь өмнөх жилийн оролцогчийн тоотой харьцуулахад ойролцоо буюу жил бүр 200 гаран илтгэгч илтгэлээ илгээдэг нь 100% оролцоотой байна. Уралдаанд оролцсон багш, байгууллага, хамт олонд I болон II шатны батламжийг Боловсролын Ерөнхий Газрын ebatlamj.agency.edu.mn цахим хаягаар дамжуулан олгосон бөгөөд II шатанд шалгарсан илтгэлийн хураангуйг багтаасан цахим номыг олон нийтэд нээлттэй хүргүүлээд байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.2. | Бүх түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион | - | - | - | - | | •Сургуулийн өмнөх болон бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх , холбогдох талуудад хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх | | | | | хэрэгжүүлэх менежментийн зураглал боловсруулах зорилгоор туршилт хийж 10 аймгийн жишгээр хөтөлбөр хэрэгжүүлэх менежментийн зураглал боловсруулж, СӨБ болон бага боловсролын түвшинд хэрэгжүүлэх нэгдсэн зураглалыг мэргэжлийн байгууллагад танилцуулав. Зураглалын дагуу СӨБ-ын багш, удирдах ажилтнуудад зориулсан сургалтын ерөнхий удирдамжийг боловсруулж, сургалт зохион байгуулах бэлтгэл хангаж байна. •2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Математик, мэдээллийн технологи, хими, хөгжим зэрэг хичээлүүдийн төлөвлөлт, заах арга зүй, үнэлгээний зөвлөмжийг боловсруулж, багш нарт түгээн, БГ-ын мэргэжилтнүүдэд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим уулзалтаар танилцуулан, сайн туршлагаа харилцан солилцож хамтран ажилласан. •2024–2025 оны II улирлын бие даалтын 7 хоногийг “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн хүрээнд чиглэлийг баталж, аймаг нийслэлийн Боловсролын газарт албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тус чиглэлийг Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн. Үүний үр дүнд "Аюулгүй амьдрах ухаан" хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн. •Нийслэл, орон нутгийн нэг ээлжтэй сургуулиудын жишиг сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, сургалт болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг дэмжсэн төлөвлөлтийн төсөл бэлтгэн ажиллаж байна. •Сургуулийн өмнөх боловсрол бага | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад СӨБ болон ЕБ-ын шинэчилсэн хөтөлбөрийг танилцуулах подкаст, видео бэлтгэж, “Цахим аялал” контентыг 8000 гаруй багшид танилцуулсан. •Бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, орчны судалгаа хийж, 200 гаруй удирдлагад танилцуулан зөвлөмж өгч, Mlab системээр 701 сургуулийн орчны мэдээллийн сан бүрдүүлэв. Хавсралт: 11 файл | | |
| 1.2.1 | Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийн зураглал | - | Зураглалын дагуу төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 30 | 100 | Сургуулийн өмнөх болон бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийн зураглал боловсруулах зорилгоор 2025 оны 3 дугаар сард шинэчилсэн сургалтын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал суудлагдахуун бүрийн агуулга аргазүй, залгамж холбоо үнэлгээний чиглэлээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулан, зөвлөн тусалж хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | | | | | | хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж буй 10 аймгийн боловсролын газар болон туршилтын сургуулиудад ажлын байранд нь очиж зөвлөн тусалсан. Энэ хүрээнд тухайн орон нутгийн онцлогт нийцсэн, шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийн зураглал, төлөвлөгөөний төслийг боловсролын газрын мэргэжилтнүүд болон сургуулийн удирдлагуудтай хамтран боловсруулав. 4 дүгээр сард сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор менежментийн нэгдсэн зураглал боловсруулж, Боловсролын яамны холбогдох мэргэжилтнүүд, Боловсролын Судалгаа, Үнэлгээний Хүрээлэн, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, аймаг, нийслэлийн боловсролын газрын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжилтнүүдэд танилцуулан санал авч, удирдлага, мэргэжилтнүүдийн түвшинд дэлгэрэнгүй танилцуулга хийсэн. Зураглалын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж төлөвлөгөөг БЕГ, БСҮХ, МУБИС хамтран боловсруулж байна. 2025-2026 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор орон нутаг болон сургалтын байгууллагын түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх менежментийн зураглалын хүрээнд дараах чиглэлээр бэлтгэл хангаж ажиллав. Үүнд, СӨБ-ын багш, удирдах ажилтнуудад зориулсан сургалтын ерөнхий удирдамжийг боловсруулж, шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжлийн байгууллагуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Мөн хэрэглэгдэхүүний жагсаалтыг гарган бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт: 5 файл | | |
| 1.2.3 | Үнэлгээний үр дүнд суурилан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулах, түгээн дэлгэрүүлэх | - | Боловсруулсан зөвлөмжийн тоо | ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйн хүрээнд нийт 32 зөвлөмж боловсруулж БЕГ-ын сайтад байршуулж, цахим хэлбэрээр түгээсэн. | 5 | 8 | 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор: - Бага боловсролын математик хичээлийн “Тоо тоолол” агуулгыг судлахад шаардлагатай, нэгж хичээлийн төлөвлөлтийг сайжруулах, цахим хэрэглэгдэхүүнийг ашиглах зөвлөмжийг боловсруулж, 4-р ангийн 55 багш, 1200 суралцагчийг оролцуулан зөвлөмжийг платформд байршуулан туршсан. - Бага боловсролын 1-2-р ангийн "Компьютерын ухаан" -ы хөтөлбөр боловсруулахад үнэлгээ, үнэлгээний | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгуур, арга зүйн зөвлөмж бичиж эцэслэх ажлыг хөтөлбөрийн багийн гишүүдтэй хамтран гүйцэтгэсэн.Туршилтийн 3 сургуулийн багш нарт туршилтийн агуулгаар үнэлгээний шалгуур боловсруулан явцын үнэлгээ хийх арга зүйн зөвлөмж өгч, онлайн сургалт зохион байгуулсан. -Суурь боловсролын мэдээллийн технологи хичээлийн бичгийн шалгалтын тайлантай танилцан "Хүснэгтэн мэдээлэл боловсруулах технологи агуулгын хүрээнд хүснэгттэй ажиллах, томьёо оруулах, муж, тогтвортой хаяг, график гэх мэт сургалтын хөтөлбөрт тусгагдсан ойлголтуудыг дадлага байдлаар заах нь зүйтэй" гэсэн санал дүгнэлтээр өмнө нь боловсруулсан арга зүйн зөвлөмжийг мэргэжлийн багш нарт түгээсэн. -Химийн судлагдахууны гүйцэтгэлийн дундаж 2023 онд 50.3%, сул | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | агуулга 10 дугаар ангид Химийн кинетик 11 дүгээр ангид Цахилгаан хими. 2024 онд 50,6%, сул агуулга 7 дугаар ангид Материалын шинж, 10 дугаар ангид Химийн кинетик юм. Танин мэдэхүйн задлан шинжлэх түвшний даалгавар доогуур гүйцэтгэлтэй дүгнэгдсэн. Иймд аймаг, нийслэлийн мэргэжилтнүүдэд цахим уулзалтаар танилцуулан, сайн туршлагаа харилцан солилцож хамтран ажилласан. - Хөгжмийн хичээл хамгийн бага гүйцэтгэлтэй болон өндөр гүйцэтгэлтэй агуулгын суралцахуйн зорилтыг шинжилж, хөнгөн ба хүнд агуулгыг тодорхойлов.Аймаг, дүүргийн ЕБС-ийн 2024 оны хөгжмийн судлагдахууны бичгийн шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээтэй харьцуулахад улсын хэмжээнд 2-р анги хамгийн бага гүйцэтгэлтэй үнэлэгдсэн тул | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжмийн багш нарт зөвлөмж хүргэв.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.2.4 | Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/181 дүгээр тушаал болон Боловсролын сайдын 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд “Бие даалтын 7 хоног”-ийн сургалт, үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах | - | Зөвлөмжийн тоо | Боловсролын яамны сайдын 2024 А/75 дугаар тушаалын хэрэгжилтийн тайлан. | 1 | - | 2024-2025 оны II улирлын Бие даалтын 7 хоногийг “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн хүрээнд: •Бие даалтын 7 хоногийг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан БЕГ-ын дарга болон ОБЕГ-ын дэд даргаар батлуулсан. •Бие даалтын долоо хоногт зохион байгуулах үйл ажиллагааны чиглэлийг боловсруулж батлуулан, аймаг нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн бөгөөд тус чиглэлийг БЕГ-ын пэйж хуудсаар дамжуулан постер, видео контент хэлбэрээр эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийг мэдээллээр хангасан. •Нийслэлийн ЕБС-ын дунд, ахлах ангийн сурагчдыг ГХСАЗТөв 116-р ангид 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 04 | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл сургалтад хамруулах хуваарь гаргаж нийт 2400 орчим суралцагчийг 6 танхимын хичээлээр гамшгаас хамгаалах анхан шатны сургалтад хамруулсан. •Бие даалтын 7 хоногийн хүрээнд БЕГ-ын пэйж хуудас болон ОБЕГ, ГХСАЗТөвийн пэйж хуудсаар видео контент, постер,ОБЕГ-ын бэлтгэсэн “Аврагч мазаалайн зөвлөмж” гамшгийн эрсдэлээс хамгаалах агуулгатай контент, мэдээлэл зэргийг бэлтгэн олон нийтэд түгээсэн бөгөөд хандалтын тоо 28 000-161 000 хүртэл байна. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд сурагчдын гамшиг, аюулт үзэгдэлд хариу үзүүлэх мэдлэг бүх төрлөөр нэмэгдсэн бөгөөд сурагчдаас авсан судалгаагаар “Газар хөдлөлтийн дараа барилгаас гарахдаа баримтлах дүрэм”-ийн мэдлэг хамгийн өндөр өсөлттэй буюу +14%, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахилгаанаас үүдэлтэй галыг унтраах мэдлэг +9%, хөлдөлтийн үеийн анхны тусламжийн мэдлэг +9% гэх зэргээр өссөн дүн үзүүлжээ. Энэ нь тус 7 хоногт гамшиг эрсдэлийн чиглэлээр сургалт, үйл ажиллагаа сайн явагдсаны үр дүн юм. Харин ой, хээрийн түймрийн үед авах арга хэмжээний талаарх мэдлэг өсөлтгүй байгаа тул энэ чиглэлээр нэмэлт сургалт шаардлагатай.Судалга анд оролцогчдын хариулт,сэтгэгдлээс үзэхэд сурагчид гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг аврах анхан шатны мэдлэг чадвараа сайжруулах нь маш чухал гэж үзэж байгаа тул тус хөтөлбөрийн хэрэгжилтийг цаашид байнга дэмжиж ажиллах шаардлагатай байна.<br>Хавсралт: 7 файл | | |
| 1.2.5 | Нэг ээлжтэй ерөнхий боловсролын сургуулийн | - | Боловсруулсан жишиг төлөвлөлтийн тоо, цахимаар | - | 1 | 100% | Үндэсний хэмжээнд төрийн өмчийн сургуулиудаас нэг ээлжээр хичээллэдэг | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хичээл болон хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааны жишиг төлөвлөлт боловсруулах, танилцуулах | | түгээсэн тоо | | | | 229 сургууль байна, үүнээс нийслэлд 20 сургууль, орон нутагт 209 ерөнхий боловсролын сургууль байна. Нэг ээлжтэй сургуулийн сургалт болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг дэмжсэн жилийн болон сарын жишиг төлөвлөлтийг хувилбартайгаар боловсруулан ажиллаж байна. Тус төлөвлөлтөд сургалтын үйл ажиллагаа, сургалтыг дэмжих үйл ажиллагаа, багшийн хөгжил, хүүхэд хөгжүүлэх чиглэлийн үйл ажиллагааг багтаан төлөвлөж байна. Энэ ажлын хүрээнд нийслэлийн Эрин эверист сургууль, 112 дугаар сургууль, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын “Мэргэд” сургууль, Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагаа, хүүхэд хөгжүүлэх жилийн болон сарын төлөвлөлт дээр | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллаж анализ хийж судалсан. Эхний хагас жилд жишиг төлөвлөлтийг хувилбартайгаар боловсруулж, сайжруулж байна, ирэх хичээлийн жилээс нэг ээлжтэй сургуулиудад түгээж, хэрэгжилтийг хангана.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.2.6 | Сургуулийн өмнөх боловсрол бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтын цахим сан, контент боловсруулан платформд байршуулж, түгээн дэлгэрүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Боловсруулсан контентийн тоо | - | 10 | 20 | Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг олон нийтэд таниулах контент бэлтгэх, түгээх ажлын хүрээнд цэцэрлэгийн багш, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан "Чанга уншлагын арга зүйг нэвтрүүлэх нь" видео хүргэх ажлаар Баянзүрх дүүргийн 10, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр цэцэрлэгт, Тоглоом болон зохиолд суурилсан арга зүйн видео, подкаст хийх ажлын бэлтгэл буюу сургалт үйл ажиллагааны бичлэгийг Сүхбаатар дүүргийн 1, Чингэлтэй дүүргийн | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 275, Сонгинохайрхан дүүргийн 110 дугаар цэцэрлэгүүдэд хийж байна. "Цахим аялал" интерактив контентыг таниулах, хэрэглээ болгох онлайн сургалтыг НҮБ-ын Хүүхдийн сан, Номадик контент ХХК, БАБХГ-ын СӨБ хариуцсан 2 мэргэжилтэнтэй хамтран 1 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Тус сургалтад 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн орон нутгийн өмчийн 1024 цэцэрлэгийн 8000 багш, арга зүйч хамрагдсан. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажлын хуваарь гаргаж нэгжийн удирдлага, БЕГ, БСҮХ, БЯ-ны шатанд танилцуулсан. Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг олон нийтэд танилцуулах зорилгоор 2 минут 35 секундийн богино хэмжээний видео шторк бэлтгэн ирэх хичээлийн жилийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эхэнд бүх сургалтын байгууллага, олон нийтэд түгээхэд бэлтгэж байна. Хавсралт: 3 файл | | |
| 1.2.7 | Бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүний судалгаа гаргаж, бэлэн байдлыг хангах, зөвлөмж, чиглэл боловсруулж хүргүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэглэгдэхүүний бэлэн байдлыг хангасан сургуулийн хувь | - | - | 20 | Бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд хөтөлбөр боловсруулах багаас тухайн судлагдахууны хэрэглэгдэхүүний жагсаалтын судалгааг гаргаж өгч байна. Бэлэн байдлыг хангах зорилгоор долоо хоног бүрийн БЕГ-ын мэдээлэл солилцох цагаар Бага боловсролын 9 судлагдахуун хөтөлбөрийн шинэчлэлийн үндэслэл, зорилго, агуулга арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн гэсэн чиглэлээр танилцуулга хийж аймаг, нийслэлийн Боловсролын газар, Боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтэн нийт 200 гаруй хүнд танилцуулсан. Мөн Боловсролын газар, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургуулиудад шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах хэрэглэгдэхүүний багц, орчны шинэчлэл, сайжруулалт, дотоод цахим сан бүрдүүлэлт зэрэг судалгааг хийж, бэлэн байдлыг ханган ажиллахыг зөвлөв. 8 дугаар сард ерөнхий боловсролын сургуулиудын шинэ хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах, хэрэглэгдэхүүний бэлэн байдал зэрэг судалгаа бэлэн болно. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний менежментийг сайжруулах Mlab цахим бүртгэлийн систем 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 701 сургуулийн шаардлага хангасан анги, кабинет, лаборатори + багшийн нэмэгдэл гэсэн чиглэлээр өгөгдөлд суурилсан мэдээллээ танилцуулж, цаашид шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлэн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдлыг хангахад хамтран ажиллаж байна. Хавсралт: 2 файл | | |
| 1.3. | Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулга, аргазүй, үнэлгээг боловсронгуй болгох ажлын хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | - | - | - | - | | 2024–2025 онд СӨБ, бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, зөвлөн туслах, багшийн хөгжлийг дэмжих олон талт ажлуудыг гүйцэтгэв. СӨБ-ын математикийн хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ, төлөвлөлтөд нарийвчилсан шинжилгээ хийж, багшийн гарын авлага, суралцахуйн зорилго, дасгал ажлуудыг боловсруулан 4 удаагийн уулзалтаар 72 багшид танилцуулав. Туршилтын цэцэрлэгүүдэд хичээлд сууж, багш, эцэг эх, хүүхдүүдтэй ярилцлага хийж зөвлөмж, тайлан боловсруулллаа. Бага боловсролын хичээлүүдээр 1–5 дугаар ангийн шинэчилсэн хөтөлбөр, | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурагчийн гарын авлага, дасгал дэвтэр боловсруулж, 15 сургуулийн 75 багштай хамтран хэрэгжүүлэв. Сургууль дээр хичээл ажиглаж, ярилцлага хийсэн нь туршилтыг бодит дэмжсэн чухал алхам боллоо. Эцсийн найруулгыг баг бүрэлдэхүүнтэйгээр хийж, хөтөлбөрийг албан ёсоор батлуулсан. Цахим хичээлийн “Эдүтэн” системд 678 сургуулийн 342,088 сурагч хамрагдаж, багш, оюутнуудад танхим болон цахимаар сургалт зохион байгуулсан. Англи хэлний Pearson хөтөлбөрийг 676 сургуульд хэрэгжүүлж, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой дата бүрдүүлж, багш нарт зөвлөн туслав. Мөн багшийн хөгжлийг дэмжих хүрээнд MozaBook сургалт, химийн лабораторийн тоног төхөөрөмжийн талаар АХБ-ны төсөлтэй хамтран танилцуулга хийсэн. Химийн хичээлийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилт улсын дунджаас доогуур байгааг тогтоож, шалтгааныг тайлагнаж, сайжруулах чиглэлээр санал хүргүүлэв. “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймаг, нийслэлийн ЕБС-ийн нийгмийн ухааны судлагдахууны багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг БЕГ, БСҮХ, АТГ-тай хамтран цахим хэлбэрээр зохион байгууллаа. Эдгээр ажлууд нь боловсролын шинэчлэлийг бодит хэрэгжилт, багшийн чадавх, орчны сайжруулалтаар дамжуулан дэмжсэн чухал үр дүнгүүд боллоо. Хавсралт: 12 файл | | |
| 1.3.1 | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, бэлтгэл бүлгийн | - | -Хамтран боловсруулсан хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын дэвтрийн тоо - Туршилтын хөтөлбөрийг | СӨБ-ын туршилтын хөтөлбөр, багшийн гарын авлага-1, дасгал ажлын дэвтэр-1 Туршилтад 18 | СӨБ-ын туршилтын хөтөлбөр, багшийн гарын авлага-2, дасгал ажлын | 100% | 1. СӨБ-ын шинэчилсэн сургалтын математикийн хөтөлбөр, суралцахуйн үр дүн, арга зүй, төлөвлөлт, шалгуурт шинжилгээ хийсэн. 2. Сургуулийн өмнөх | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | багшийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийн туршилтын эх зохиох багт хамтран ажиллах | | хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн цэцэрлэг, багшийн тоо | цэцэрлэг, 136 багш, удирдах ажилтан | дэвтэр-2 Туршилтад 18 цэцэрлэг 136 багш, удирдах ажилтан | | боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтын бэлтгэл бүлгийн багшид зориулсан 1-4 дүгээр сард хэрэгжүүлэх гарын авлагыг багийн гишүүдийн хамт боловсруулж, бэлтгэл бүлгийн багш нарт 4 удаа боловсруулалт танилцуулах уулзалтыг зохион байгуулж, 72 багш, хөтөлбөрийн багийн 32 гишүүн оролцсон. 3. Сургалтын хөтөлбөрийн туршилтад зориулсан бэлтгэл бүлгийн хүүхдийн 1-4 дүгээр сарын 109 даалгавартай дасгал ажлын 2 дэвтрийг багийн гишүүдийн хамт боловсруулж БСҮХ-д хүлээлгэн өгсөн. 4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтад зөвлөн туслах ажлаар аймаг, нийслэлийн 18 цэцэрлэгт ажиллалаа. Удирдамжийн дагуу туршилт хэрэгжүүлж буй 136 багшийн сургалт, үйл ажиллагаанд ажиглалт, CBAM-ын аргаар багш | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нартай ярилцлага хийж, сургалтын хөтөлбөрийн агуулгын тохирцыг үнэлэх хуудсаар судалгаа авсан. Бага дунд ахлах бэлтгэл бүлэг тус бүрээс сонгогдсон эцэг эхтэй бүлгийн ярилцлага хийж тайланг БСҮХ-д хүргүүлсэн. Хавсралт: 3 файл | | |
| 1.3.2 | Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, багш, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийн туршилтын эх зохиох, хянах багт хамтран ажиллах | - | Хамтран боловсруулсан хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын дэвтэр, эхийн тоо, Туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн цэцэрлэг, сургууль, багшийн тоо | ЕБС-ийн 5 судлагдахууны хөтөлбөр, сурагчийн гарын авлага-21 боловсруулалт 40%, дасгал ажлын дэвтэр-21 боловсруулалт 40% , Туршилтын 15 сургууль. | ЕБС-ийн 5 судлагдахууны хөтөлбөр, сурагчийн 21 гарын авлагыг 100% боловсруулж дуусгасан байна. Туршилтын 15 сургууль. | 100% | Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/06 дугаар "Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах багийн бүрэлдэхүүн батлах тухай" тушаалын дагуу Байгаль шинжлэл, Математик, Зураг урлал, Компьютерын ухаан, Би Монгол хүн судлагдахуунаар агуулга боловсруулагч багт СХХХ-ийн 9 мэргэжилтэн ажиллав. -Бага боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрт суралцахуйн үр дүнд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, үнэлгээний шалгуур | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг боловсруулав. 1-5 дугаар ангид дээрх агуулгаар сургалтын хөтөлбөр 5, сурагчийн гарын авлага 45, дасгал ажлын дэвтэр 45-ийг боловсруулан туршив. - Бага боловсролын туршин хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө Боловсролын сайдын 2024 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан. Байгаль шинжлэл, Математик, Зураг урлал, Компьютерын ухаан, Би Монгол хүн хичээлийг нийслэл, аймаг, сумын нэг, нэг ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг бүлэгт туршин сайжруулсан. Туршилт хэрэгжүүлж буй нийслэл болон 10 аймгийн 27 сургуульд очиж зөвлөн тусалж, хичээлд сууж, агуулгын тохирц болон даалгаврын тавил зэргийг сайжруулах саналыг цуглуулан, багш, эцэг эх, сурагчидтай ярилцлага | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийв. - Бага боловсролын 10 судлагдахууны хичээлийг туршин хэрэгжүүлж буй 27 сургуулийн 135 багшид агуулга, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулсан, мөн 14 хоног тутамд онлайнаар холбогдож тухайн долоо хоногийн агуулга, заах арга зүйг хэлэлцэн, туршлага солилцож хамтран ажилласан. -БСҮХ-ээс 3-6 дугаар сард зохион байгуулсан вакум сургалтад хамрагдаж бага боловсролын хөтөлбөрийг эцэслэн боловсруулж, эх бэлтгэн хэвлүүлэх, мэргэжлийн зөвлөлд хүлээлгэн өгөх ажлыг хөтөлбөрийн багийн гишүүдтэй хамтран гүйцэтгэв.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.3.3 | Суурь, боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, | - | -Хамтран боловсруулсан хөтөлбөр, гарын авлага, дасгал ажлын | -ЕБС-ийн 9 судлагдахууны хөтөлбөр, сурагчын гарын авлага- | 9 | 9 | Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, багш, сурагчийн гарын авлага, дасгал ажлын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | багш, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийн туршилтын эх зохиох, хянах багт хамтран ажиллах | | дэвтэр, эхийн тоо - Туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн сургууль, багшийн тоо | 0, дасгал ажлын дэвтэр-0, туршилтын сургууль-0 | | | дэвтрийн туршилтын эх зохиох, хянах багт хамтран ажиллах саналыг СХХХ-ийн судлагдахуун хариуцсан 11 мэргэжилтэн БСҮХ-нд өгсөн ба үүний дагуу хөтөлбөрийн шинэчлэл, үзэл баримтлалын талаарх сорил судалгаа, даалгаврыг гүйцэтгэсэн. Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/101 дүгээр "Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу 2025 онд СӨБ ба бага боловсролын 1,2 дугаар анги, 2026 онд 3-5 дугаар анги, 2027 онд суурь боловсролд, 2028 онд бүрэн дунд боловсролд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн байсан боловч бага боловсролын хөтөлбөр, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтэр боловсруулах явцад 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Боловсролын сайдын А/87 тоот “Журам батлах тухай”, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ХЗДХ-ийн сайдын 1/2076 тоот албан бичгийн хүрээнд сурах бичгийн эх зохиох, хэвлэх тендер зохион байгуулах, хэвлэх үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд заасан хугацаагаар зохион байгуулах болсон тул суурь боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааны хугацаа нь хойшилсон болно. Иймд суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах багт ажиллах үйл ажиллагаа хойшилж, энэ хугацаанд өөрийн судлагдахууны хэмжээнд судалгаа хийх, бага боловсролын агуулгатай уялдуулах, залгамж холбоотой төлөвлөх, олон улсын сургалтын хөтөлбөрийн жишээ, сурах бичгийн агуулга, даалгаврын тавил зэргийг орчуулан судалж байна. Мөн орчин үеийн цахим технологиор боловсруулалт хийж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгаа үйл ажиллагаа, дрон программчлалын үйл ажиллагааг судалж суурь боловсролын судлагдахуун бүрийн хөтөлбөрт зохицох боломжуудыг судалж байна.<br>Хавсралт: 3 файл | | |
